

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар:

Хөвсгөл аймагт 2023 оны 04 дүгээр сарын 24 нд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба, Стратеги судалгааны хүрээлэнгийн хамтарсан ажлын хэсэг ажиллалаа.

Тус ажлын хэсэг аймгийн Засаг даргын ахалсан Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах, орон тооны байнгын ажлын хэсгийн үйл ажиллааг шалган танилцаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон асуудлаар аймгуудад батлагдсан удирдамж, хуваарийн дагуу сургалт зохион байгуулсан.

Сургалтад үндэсний аюулгүй байдлыг хамгаалах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагын удирдлага, албан хаагчид хамрагдлаа.

2023 оны Төрийн архивын сан хөмрөгийн нөхөн бүрдүүлэлтийн төлөвлөгөөний дагуу 4 хөмрөгийн 717 хадгаламжийн нэгжийн 34801 хуудас бүхий цаасан суурьтай баримтаар нөхөн бүрдүүлэлт хийсэн.

Мөн 04 дүгээр сард 8 хөмрөгийн 225 хадгаламжийн нэгжийн 14850 хуудас баримтыг цахим хэлбэрт шилжүүлсэн байна.

Иргэд, байгууллагын хүсэлтийн дагуу 256 иргэн, 8 байгууллагад архивын баримтын лавлагаа мэдээллийн үйлчилгээг хүргэж ажиллалаа.

Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын байцаагчийн 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний хүрээнд 3 байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж цаашид хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, зөрчил арилгуулах чиглэлээр 2 байгууллагад албан шаардлага, 1 байгууллагад зөвлөмж хүргүүлсэн.

Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сум 2023 оны 04 дүгээр сарын 28-29-ний өдрүүдэд суман дахь “Төрийн албан хаагчдын зөвлөгөөн”-ийг зохион байгуулж аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга, БШУГ-ын бага боловсрол хариуцсан мэргэжилтэн, ЭМГ-ын НЭМТ-ийн өсвөр үеийн арга зүйч нар тус сумын төрийн албан хаагчдын зөвлөгөөнд оролцон, чиглэл тус бүрээр мэдээлэл өгч, аргазүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Хоёр. Хууль, эрх зүйн хүрээнд:

Онцгой байдлын чиглэлээр:

Хөвсгөл аймгийн хэмжээнд 2023 оны 04 дүгээр сард ой хээрийн түймэр 1 суманд 1 удаа ,объектын гал түймэр- 6 суманд нийт 12 удаа гарч өвөл, зуны сууц- 1, 5 ханатай монгол гэр- 2, малын хашаа- 5, автомашин- 3, Хураалгаатай барилгын материал шатсан байна. Ой хээрийн түймрийн улмаас байгаль экологид 63,690 /Жаран гурван мянга зургаан зуун ерэн төгрөг/ -ийн хохирол, сум орон нутаг болон Онцгой байдлын байгууллагаас 994,808 /Есөн зуун ерэн дөрвөн мянга найман зуун найман төгрөг/ -ийн зардал, нийт 1,058,498 /Сая тавин найман мянга дөрвөн зуун ерэн найман төгрөг/ -ийн хохирол учруулсан байна

Галын аюулгүй байдлын тухай хууль, зөрчлийн тухай хууль тогтоомж зөрчсөн 8 иргэнийг 800,000 /Найман зуун мянган төгрөг/-ний торгуулийн арга хэмжээ авч, Галын аюулгүй байдлын тухай хууль, улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 33.1.4 дахь заалтын дагуу аж ахуйн, нэгж байгууллагад ажлын байрны аюулгүй байдлын дүгнэлт-5 олгож, орон нутгийн орлогод нийт 925,000 /Есөн зуун хорин таван мянган төгрөг/-ний орлого төвлөрүүлэн ажилласан байна.

Тайлангийн хугацаанд гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага-25, мэдэгдэл-10 гал түймэр гарсан тухай акт-8 зэрэг эрх зүйн бичиг баримт үйлдэн ажилласан байна.

Монгол Улсын Шадар сайдын 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр баталсан “Гэр хорооллын айл өрхүүдийн галын аюулгүй байдал, урьдчилан сэргийлэх арга хэмжээ”-ний удирдамж, “Олон улсын иргэний хамгаалалтын өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх нэгдсэн удирдамжуудын хэрэгжилтийг ханган ажилласан.

Удирдамжид ажлын хүрээнд Онцгой байдлын газрын даргаар “Галын аюулгүй байдлыг хангуулах үзлэг шалгалтын удирдамж” боловсруулан Гал түймэр унтраах 5 анги, Эрэн хайх аврах салбарын алба хаагчдын хуваарь гарган урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулсан.

Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан урьдчилан сэргийлэх ажлыг хүргэх ажлын хүрээнд Хөвсгөлийн гэр бүлүүд радио, Хөвсгөл Ард түмний телевиз, Далай ээж телевизүүдтэй Гамшгаас хамгаалах хуулийн 10 дугаар зүйлийн 10.5, 16 дугаар зүйлийн 16.2, 16,3 дугаар зүйлийг үндэслэн гэрээ байгуулсан.

Гурав. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд:

Төрийн сангийн төлбөр тооцооны программаар 2023 оны 04-р сард 81 Төсөвт байгууллагын үндсэн болон нэмэлт санхүүжилтийн данснаас **9.7** тэрбум төгрөгийн **2147** ширхэг гүйлгээ шивэгдсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн 2023 оны 04-р сарын мэдээгээр Орон нутгийн орлого, санхүүжилт 13,511.2 сая төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс 15,757.1 сая төгрөг буюу 116.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн гүйцэтгэл 2023 оны 04-р сарын мэдээгээр Орон нутгийн байгууллагуудын төсвийн зарлагын гүйцэтгэл батлагдсан 19,201.1 сая төгрөг байгаа бөгөөд үүнээс 131.8 сая төгрөг нь татварын бус орлого буюу өөрийн орлогоос, 2,248.0 сая төгрөг нь төсвөөс санхүүжих, 1,831.0 сая төгрөг нь улсын төсөв болон орон нутгийн төсвөөс тус тус санхүүжигдсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээнд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр 19,201.1 сая төгрөг, зарлагын гүйцэтгэл 10,336.5 мянган төгрөг буюу 53.8 хувьтай байна.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр Төсвийн нийт авлага **5,052.2** сая төгрөг өмнөх сараас **46.4** сая төгрөгөөр өссөн.

Нийт өглөг **623.0** сая төгрөг өмнөх сараас **16.8** сая төгрөгөөр өссөн.

2023 оны 04 сарын байдлаар нийгмийн даатгалын санд шимтгэлийн орлого 3126.4 сая төгрөг, сайн дурын даатгуулагчаас 246.1 сая төгрөгийн орлого орж орлогын төлөвлөгөө 98.7 хувьтай байна.

Төлөвлөгөөг сан тус бүрээр нь харуулбал:

Төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Тэтгэвэр	2262.4	2975.7	131.5
Тэтгэмж	227.6	306.9	134.8
ҮОМШӨ	198.4	172.8	87.1
ЭМД	0,0	0,0	0,0
Ажилгүйдэл	40.2	65.7	163.4
Дүн	2728.6	3521.1	129.2

Тэтгэврийн даатгалын сангаас 21494 тэтгэвэр авагчид 11043.1 сая төгрөгийн 4 төрлийн тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын сангаас 3 төрлийн тэтгэмж 274 даатгуулагчдад 314 сая төгрөгийн тэтгэмжийн зардал, үйлдвэрлэлийн ослын сангаас 91 даатгуулагчдад 38,2 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмж, ажилгүйдлийн даатгалын сангаас 175 даатгуулагчид 101.3 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж олгосон байна.

Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 132.6 сая төгрөг байна.

2023 оны 04 дүгээр сард Сангийн сайдын 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн СХШХ/02 дугаар удирдамжаар батлагдсан “Нийгмийн даатгалын ерөнхий газар болон түүний харъяа газар, хэлтсийн санхүү, үйл ажиллагаа, сангуудад хийх нэгдсэн хяналт шалгалтын удирдамж”-ийн дагуу аймгийн Нийгмийн даатгалын хэлтэст санхүүгийн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

Урлаг, утга зохиолоор дамжуулж, хүүхдийн хүмүүжил, хандлага төлөвшилд эерэг нөлөө үзүүлэх, тэдний бүтээлч сэтгэлгээ, авьяас чадварыг хөгжүүлэх зорилгоор Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын 31 сургуульд “Утга зохиолын дугуйлан байгуулж”, албан ёсоор үйл ажиллагаагаа эхлэв.

ЕБС-ийн 9 дүгээр ангийн "Монгол хэл, бичгийн анги нийтийн олимпиад"-ын I даваа /89 бүлгийн 2538 сурагч/, II даваа /33 ангийн 943 сурагч/, III даваа /11 ангийн 342 сурагч/ аймгийн хэмжээнд зохион байгуулж, аймагтаа тэргүүлсэн 10 ангийг "Эх хэл, бичиг соёлоо эрхэмлэгч шилдэг анги, хамт олон"-оор батламжлав.

Хөвсгөл аймгийн СӨБ-ын байгууллагад эхний болон тав, арав дахь жилдээ ажиллаж буй багш нарын мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалт Мөрөн хотноо БШУГ-ын “Боловсрол”, “Эрдэм” танхимд амжилттай зохион байгуулагдаж нийт 58 багш хамрагдав.

БШУ-ы сайдын “2023 оныг сургалтын байгууллагын менежментийг сайжруулах жил болгон зарлах тухай” А/01 дүгээр тушаалын дагуу Боловсролын ерөнхий газрын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, гүйцэтгэлийн үнэлгээ хөгжүүлэлтийн газрын дарга Т.Даваасүрэнгээр ахлуулсан баг Ханх сумын ерөнхий боловсролын сургуульд зөвлөн туслах чиглэлээр ажиллав.

Боловсролын ерөнхий газрын Насан туршийн боловсролын хэлтсийн дарга Г.Одбаатараар ахлуулсан баг Түнэл сумын ерөнхий боловсролын сургуульд Сургуулийн удирдлага манлайлал, Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, багшийн хөгжил, Хүүхэд хөгжил хамгаалал, Сургалтын орчин чиглэлээр ажиллав.

Хөвсгөл аймгийн БШУГ-аас аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Эрүүл мэндийн газар, Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран, “Хүүхдийн хоол” сэдэвт хэлэлцүүлгийг Мөрөн сумын Дэлгэрмөрөн цогцолбор сургууль дээр зохион байгуулж, хэлэлцүүлэгт сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч, Сургуулийн хоол зүйч, сургууль, цэцэрлэгийн нярав, тогооч, Хүнс бэлтгэн нийлүүлэгч аж ахуйн нэгжийн удирдлага, төлөөлөл танхимаар 91, цахимаар 23 сумын сургууль, цэцэрлэгээс 215, нийт 306 хүн оролцов.

“JICA START-2 "Тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдүүдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл"-ийн мэргэжилтэн Ё.Исобэ, Монгол дахь төслийн зохицуулагч Х.Ганбаатар, БШУЯ-ны ахмад мэргэжилтэн Гэрэлтуяа, Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 12-р цэцэрлэгийн арга зүйч А.Галбадрах нар БШУГ-ын холбогдох албаны хүмүүстэй уулзалт хийж, төсөл хэрэгжиж буй Мөрөн сумын I цэцэрлэг, Сод-Эрдэм ЕБС, Тариалан сумын хүүхдийн цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургуулиудад ажиллаж, төслийн хүрээнд тухайн сургалтын байгууллага дээр хийгдсэн ажилтай танилцаж, ерөнхий боловсролын 10 сургууль, 16 цэцэрлэгийн нийт 106 багшид "Тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхэдтэй ажиллах арга зүй"-н сургалтыг зохион байгуулав.

Бага боловсролын хөгжмийн боловсрол “STEM” чадварыг дэмжих үйл ажиллагааны хүрээнд хөгжмийн хичээлийн сургалтын хөтөлбөрийн агуулга, зорилготой уялдуулан сурагчийн бүтээлч суралцахуйг дэмжих зорилгоор "Хөгжмийн үзүүлбэр-2023" үйл ажиллагаа Сод-Эрдэм сургуулийн урлаг танхимд зохион байгуулагдлаа. Тус наадамд төвийн 7 сургуулийн 11 бүлгийн 350 сурагч оролцов.

Гадаад хэлний багш нарыг чадавхжуулах сургалт, зөвлөгөөнд хамруулах, сурагчдыг хэлний зуны зусланд хамруулах боломж, бололцоогоор хангах зорилгоор Филиппин улсын “Winning English academy”-тай хамтран ажиллах талаар ЭДЦС, Титэм ЕБС-ийн удирдлагуудтай уулзалт хийж, гэрээ байгуулан ажиллав.

Танхимын сургалтад Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын 31 сургуулийн 1, 5, 10 дахь жилдээ ажиллаж буй 270 багш хамрагдав.

"Бүтээлч багачууд СТЭМ" боловсролын улсын уралдааныг сургууль, бүсийн хэмжээнд Улсын уралдаанд оролцох эрхийг 2 үе шаттай 5 ангиллаар зохион байгуулан шалгаруулж тайланг хүргүүлсэн байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Хөвсгөл аймагт 2023 онд Глобал сангийн дэмжлэгтэйгээр “Монголын Сумын Эмч Мэргэжилтний Холбоо”-ны хэрэгжүүлж буй төслийн хүрээнд аймгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, МСЭМХ-ны Хөвсгөл аймаг дахь салбар хороо хамтран Тосонцэнгэл, Тариалан Бүрэнтогтох, Цагаан-Уул, Цэцэрлэг, Хатгал, Алаг-Эрдэнэ, Галт, Төмөрбулаг, Жаргалант, Улаан-Уул, Арбулаг зэрэг сумдад зорилтот бүлгийн хүн ам, сүрьеэгийн хавьтлын үзлэгийг зохион байгуулж ажиллалаа.

МСЭМХ-ны МСЭМХ-ны Хөвсгөл аймаг дахь салбар зөвлөл, Монголын Эрүүл Мэндийн Чанарын Холбоотой хамтран “Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах нь, Магадлан итгэмжлэлийн шинжээчийн үнэлгээнд хамрагдахад анхаарах асуудлууд” 2 өдрийн сургалт зохион байгуулав.

Төр, Хувийн хэвшлийн 40 эрүүл мэндийн байгууллагын 120 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд “Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах нь” “Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллага болоход анхаарах асуудал” зэрэг сургалтууд амжилттай зохион байгууллаа.

Монгол Улсын “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” болон Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэн төлөвшүүлэх зорилтын хүрээнд “Энэ жилдээ-Эрүүл жиндээ” аяны нээлт ажилттай зохион байгуулагдаж Эрүүл мэндийн нийгмийн ажилтан нарыг чадавхжуулах сургалтыг 3 өдөр зохион байгуулав.

Аяны нээлтийн үеэр Мөрөн сумын Өрхийн Эрүүл мэндийн төвийн Нийгмийн эрүүл мэндийн ажилтнууд зөв зохистой хооллолтын талаар хоолны үзэсгэлэн гаргаж, харилцан туршлагаа солилцлоо.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ХАЛАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Нийгмийн халамжийн ehalamj.mn системээр 2023 оны 4 сард 71772 иргэнд 6.6 тэрбум төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлт, тусламж олгосон.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн салбар комисс 4 дүгээр сард 1 удаа хуралдаж, 20 хүүхдийн асуудлыг хэлэлцэж, 11 хүүхдийн байнгын асаргааг сунгаж, шинээр 7 хүүхдийг асаргаанд оруулсан.

Мөн 1 хүүхдийн өргөдлийг буцааж, 1 хүүхдийн оношийг тодруулах шийдвэр гарган ажиллав.

Хөдөлмөр эрхлэлтийн нэгдсэн систем “E-JOB”-д ажил хайгч иргэн 536, аж ахуй нэгж, байгууллагаас ажлын байрны 47 захиалга авч бүртгэн, мэдээллийн баазыг шинэчилж, ажлын байрны захиалга ирүүлсэн аж ахуй нэгж, байгууллагуудад 62 иргэний мэдээллийг хүргүүлсэн.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээний хүрээнд Тариалан, Тосонцэнгэл, Рашаант, Их-Уул сумын ЕБС-ийн 316 сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт зохион байгуулж, чадавхжуулсан. Аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх, мэдээллийг нэгтгэх талаар дээрх сумдын удирдлага, ажил олгогч нарт мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллалаа.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2023 онд олгох санхүүгийн дэмжлэгт хамрагдах иргэдийн төслийг хүлээн авч, сумын хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн нөхцөл байдлын үнэлгээ хийж байна.

Мөрөн сумын Титэм ЕБС-ийн захиргаа, уг сургуулийн үйлдвэрчний эвлэлийн хоорондын хамтын гэрээ байгуулсныг хууль, журмын дагуу бүртгэсэн.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн дэмжлэгт 2015-2022 онд хамрагдаж санхүүгийн дэмжлэг авсан 391 иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн ажиллаж, зарим иргэн, аж ахуй нэгжийг хуулийн байгууллагад шилжүүлээ.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчлөлөөс урьдчилсан сэргийлэх ажлын хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас боловсруулсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн улсын үзлэгийг боловсролын салбарын мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудад зохион

байгуулах удирдамж"-ийн дагуу Хөвсгөл аймгийн Политехникийн коллежид 2023 оны 4 дүгээр сарын 17-21-ний өдрүүдэд зохион байгуулав.

“Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сарын аян”-ыг зохион байгуулсан. Сарын аяны нээлтийн арга хэмжээг 2023 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр онлайнаар зохион байгуулж, 23 сумын ЗДТГ-ын дарга, 1 тосгоны Захирагчийн ажлын албаны дарга, ХАБЭА-н зөвлөлийн гишүүд, байгууллагуудын ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтнууд зэрэг 84 хүн арга хэмжээнд оролцлоо.

Аяны хүрээнд байгууллагуудын дунд “Эрүүл аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага” шалгаруулах болзолт уралдааны гарааны үнэлгээг эхлүүллээ. Мөн 8-12 дугаар ангийн сурагчдын дунд “Эрүүл аюулгүй орчин хүүхэд бидний ирээдүй” сэдэвт гар зургийн уралдаан зарлан 34 зураг хүлээн аваад байна. Боловсрол шинжлэх ухааны газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас ажлын хэсэг томилогдон уралдааныг дүгнэхээр ажиллаж байна.

“Ажлын байранд болон гамшгийн үед албан хаагчдын аюулгүй байдал, сэтгэл зүйн эрүүл мэндийг хамгаалах нь” сэдэвт сургалтыг зохион байгуулав. Сургалтад аймгийн гамшгаас хамгаалах албадын ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтан, удирдлагууд, сумын Засаг даргын Тамгын газрын дарга нар, Мөрөн сумын аж ахуйн нэгж байгууллагын ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтнууд нийт 104 хүн оролцлоо.

Сургалтын хүрээнд өрнүүлсэн хэлэлцүүлгийн дүнд ХАБЭА-н тухай хуулийн 26.2-т заасан төсвийг хэрхэн бүрдүүлэх талаар нэгдсэн ойлголтод хүрсэн.

“Дэмч ир гүн” сургалтын төвтэй хамтран сумын ХАБЭА-н зөвлөл, ҮОМШӨ-ийг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссыг чадавхжуулах сургалт, ажил олгогчдын сургалтыг тус тус зохион байгууллаа.

БИЕИЙН ТАМИР, СПОРТ, СОЁЛ УРЛАГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 53-р зарлигийн дагуу бие бялдрын түвшин тогтоох сорилын зохион байгуулан ажиллаж байна.

Хөвсгөл аймгийн БТСГ, Аймгийн бүжгийн холбоо, Хэмнэл бүжгийн клуб, Аялгуу бүжгийн клуб, Баясахуй бүжгийн холбоодтой хамтран “Нийтийн Бүжигт цаг гаргая” аяныг 2023 оны 04 сарын 17-ноос 04 сарын 24-ны хооронд өглөө бүр 06:30 - 08:00 цаг хүртэл зохион байгуулж бүжгийн хичээлийг иргэдэд үнэ төлбөргүй заан сургасан.

Мөн Хилийн цэргийн 0257-Р анги, ШШГ газрын ажилтан албан хаагчид, Наран жим фитнес клуб цэрэгжсэн байгууллагуудын ажилчдад зөвлөгөө өгч “Гүйхэд Цаг Гаргая” аяны хүрээнд хамтран ажиллаж байна.

Хөвсгөл аймгийн БТС газар, аймгийн явган алхалтын холбоо 2023 оны 04 дүгээр сарын 26 -аас 2023 оны 05 дугаар сарын 01 хүртэл явган алхалтын 7 хоногийг зохион байгууллаа.

Хүүхдийн спортын VII наадмын таеквондогийн төрөлд Хөвсгөл аймгийг төлөөлөн оролцох тамирчдыг сонгон шалгаруулах болон Хөвсгөл аймгийн аварга шалгаруулах олимпын таеквондогийн тэмцээн зохион байгуулагдлаа.

Хөвсгөл аймгийн Биеийн тамир спортын газарт зохион байгуулагдсан тус тэмцээнд "Хөвсгөлийн Хүчит Шонхор", "Хөх баавгай", "Улаанбаатар Хүчит Шонхор", "Хатгал тосгон"

таеквондо клубын нийт 70 гаруй тамирчид хурд, хүч, авьяас ур чадвараараа өрсөлдөж шилдгүүдээ шалгарууллаа.

Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын уугуул ахмад харваач Бавуугийн Хаянхярваа агсны нэрэмжит 2023 оны аймгийн аварга шалгаруулах үндэсний “ШАГАЙН ХАРВААН” тэмцээнийг орон нутагт цар хүрээ өргөнтэй зохион байгуулах, дэлхийн биет бус соёлын өвийг түгээн дэлгэрүүлэх, өв уламжлалыг залгамж халаа залуу үед өвлөн үлдээх, Монгол ёс заншлаа дээдлэн хадгалж шагайн харвааны спортыг орон нутагт сурталчлан таниулах болон ахмад харваачдыг сурталчлан таниулах зорилгоор амжилттай зохион байгууллаа.

Монголын хүүхдийн спортын 7-р их наадмын анхан шатны Аймгийн аварга шалгаруулах хөнгөн атлетикийн тэмцээн зохион байгуулагдаж нийт 21 байгууллагын 300 гаруй баг тамирчид оролцлоо.

Арбулаг сумын соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгч Б.Оюунгэрэлийн “Хавар ирлээ шүү хүүхнүүд ээ” 6 ястны загварын шоу зохион байгуулагдлаа.

“Хээтэй мөнгөн бөгж” нутгийн ардын дууны номын нээлтэд зориулж Чандмань- Өндөр суманд нутгийн дууны “Хээтэй мөнгөн бөгж” дууны наадам 2 дахь удаагаа өргөн дэлгэр зохион байгуулагдав.

НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (ЮНЕСКО)-аас 1995 онд 4 дүгээр сарын 23-ныг “Дэлхийн номын өдөр” болгон зарласан бөгөөд энэ өдрийг тохиолдуулан ном уншихын ач холбогдлыг олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгууллаа. Мөн номын барын хүрээнд Эрдмийн далай цогцолбор, нутгийн аваргууд сургуульд зөөврийн номын сангаар Электрон каталогийн танилцуулга, номын сангийн танилцуулга мэдээлэл, гэрээр ном олгох журмын танилцуулга, шинэ уншигч бүртгэх, АХА тэмцээн зохион байгуулж, 250 гаруй ном хэвлэлийн бүтээгдэхүүнээр 150 гаруй уншигч иргэдэд үйлчиллээ. 7-р багийн Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чийрэгжүүлэх “Дүүрэнбилэг” төвд 80 гаруй ширхэг номыг номын буланд нь байршуулав.

Тосонцэнгэл суманд Хөгжимт драмын театрын найрал дууны ангийн багш Т.Төрмөнхийн “Аягтай аястай хорвоо” уран бүтээлийн тоглолтонд Хөгжимт драмын театрын найрал дууны анги болон хөгжим анги бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцон иргэд хөдөлмөрчдөд соёл урлагаар үйлчлэн ажиллалаа.

“Соёлын биет өвийг бүртгэх, баримтжуулах тухай ” сургалтыг Соёлын өвийн төвтэй Аймгийн төв музей хамтран сумдын Соёлын төвийн өвийн ажилтан нарт цахим сургалт зохион байгуулж нийт 70 гаруй хүн хамрагдлаа. Уг сургалтаар соёлын биет өвийг бүртгэлжүүлэхэд шаардлагатай мэргэжил арга зүйн зааварчилгааг өглөө.

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД, ЖЕНДЭРИЙН БОДЛОГО ЧИГЛЭЛЭЭР:

Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн 1 дүгээр хуралдааныг зохион байгуулж, хүүхдийн хөгжил, хамгаалал, эрүүл мэнд, боловсролын чиглэлээр зөвлөлийн гишүүдийг хангаж, тулгамдсан асуудлуудыг хэлэлцэн, аймгийн Засаг дарга бөгөөд хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүн Ш.Идэрбаягалан холбогдох гишүүдэд хугацаатай үүрэг даалгавар өгөв.

2023 оны 04 дүгээр сард 18 үйл ажиллагаа, үйлчилгээ, сургалт, нөлөөллийн ажилд 407 хүүхэд, 2328 насанд хүрэгч, 1 гэр бүл, 203 залуучууд хамрагдсан байна.

Байгууллагын фейсбүүк хуудсаар дамжуулан 2 зөвлөмж, 32 мэдээ, 1 уриалга, 1 ажлын байрны зарыг иргэд олон нийтэд хүргэж 785 хандалт авсан байна.

Байгууллагын веб сайтад 10 мэдээ байрлуулж 4777 хандалт авсан байна. “Нэг цэгийн үйлчилгээний төв”-д нийт 39 хүнд үйлчилгээ үзүүлж, түр хамгаалан байрлуулах үйлчилгээ авсан хохирогчийн мэдээллийг etuslamj.mn системд бүрэн оруулсан.

Хөвсгөл аймгийн Хүүхдийн XI чуулганы хэрэгжилтийг хангах, хүүхдийн хөгжлийг дэмжих, тэдний авьяас, чадварыг хөгжүүлэх зорилгоор Соёл, урлагийн газар, Хөгжимт драмын театраас хамтран "Дугуйлан хөгжлийн хөтөлбөр"-ийн сарын аяны хүрээнд 4 чиглэлээр сургалтууд явагдаж байна.

Хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэх чиглэлээр 4 төрлийн уралдааныг зохион байгуулж 18 сум сургууль, 28 цэцэрлэгийн 619 хүүхэд оролцлоо. Энэтхэг бүжиг, үндэсний хөгжмийн Улсын аварга шалгаруулах наадмаас 3 алт, 1 мөнгө, 5 хүрэл медаль хүртэж, 2 багш шилдгээр шалгарсан байна.

Гэр бүлийг боловсрол олгох сургалтыг 8 байгууллагын 539 эцэг эхэд хүргэлээ.

ГБХЗХГ-ын 5 мэргэжилтэн жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах чиглэлээр чадавхжиж, хамтарсан багийн ахлагч, гишүүд бүхий 80 хүнийг хууль тогтоомж, урт, дунд хугацааны бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, хүн амын бүлгүүдэд мэргэжлийн нийгмийн ажлын үйлчилгээг үзүүлэх чиглэлээр чадавхжуулж нэгдсэн арга зүйгээр хангалаа.

Гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн боловсрол олгох, тогтвортой харилцааг дэмжсэн эерэг зан үйл хандлагыг нийгэмд төлөвшүүлэх, иргэдэд сэтгэл зүйн боловсрол олгох, эцэг эх, асран хамгаалагчдын хүүхдийн төлөө хүлээх үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэн сургалт, нөлөөллийн ажил, сэтгэл зүйн оношилгоо, сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөө гэсэн үндсэн 3 чиглэлээр сэтгэл зүйчийн баг Тариалан суманд ажиллалаа.

Тав. Мал аж ахуй, газар тариалангийн талаар:

Жижиг, дунд үйлдвэрийн газрын ажлын хэсэг Мөрөн, Эрдэнэбулган, Цагаан-Уул, Ренчинлхүмбэ, Алаг-Эрдэнэ сумдын урьдчилсан судалгаанд тэнцсэн нийт 1,42 тэрбум төгрөгийн зээлийн хүсэлт бүхий 11 төслийн 3-р шатны үнэлгээг 2023 оны 04 дүгээр 24-ний өдрөөс 4 дүгээр сарын 30-ны өдрүүдэд хийж дуусгалаа.

Тодруулбал: Хөнгөн үйлдвэр 2 төсөл 341,5 сая, Хүнсний үйлдвэр- 3 төсөл 440,0 сая, Газар тариалан- 3 төсөл 260,0 сая, Мал аж ахуй- 3 төсөл 462,6 сая төгрөг байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, "Хөвсгөлд зочлох" нэрлэсэн жилийн хүрээнд 04 дүгээр сарын 27-30 ны өдрүүдэд Төв, Хангайн бүсийн аварга тогооч, зөөгч шалгаруулах "ХҮСЭХҮЙН ЦОМ- 2023" ур чадварын уралдаан Мөрөн хотод зохион байгуулсан.

Уралдааныг АЗДТГ, Монголын тогоочдын холбоо, Аймгийн тогоочдын холбоотой хамтран зохион байгууллаа. Төв, Архангай, Өвөрхангай, Булган, Орхон, Дархан-Уул, Сэлэнгэ, Хөвсгөл аймгуудаас нийт 120 гаруй тогооч, зөөгч оролцсон байна.

Ерөнхий ивээн тэтгэгчээр аймгийн ЗДТГ, "50 100" Эвэнт холл, Жаргалан зоогийн газар, Хөвсгөл "Мон тревэйл", "MCS", "Тэвхэн" худалдаа үйлчилгээний төв, HOREKA сургалтын институт оролцсон.

“Хөгжлийн Шийдэл” ТББ-ын хэрэгжүүлж буй Best хөтөлбөр, Монголын хүнсчдийн нэгдсэн холбоотой хамтран орон нутгийн сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр, цехүүдэд эгзэгтэй цэгийн хяналтын системийг нэвтрүүлэх Олон улсын /НАССР/ стандарт болон үйлдвэрийн зохистой дадал нэвтрүүлэх /GMP/, эрүүл ахуйн зохистой дадал нэвтрүүлэх /GHP/, чанарын удирдлагын тогтолцоо /ISO22000/ стандарт, хүнсний үйлдвэрлэл, бүтээгдэхүүн, үйл явцад тавигдах шаардлагууд, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн технологи, үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнийхээ өртгийг тооцох талаар мэдлэг олж авахад нь дэмжлэг үзүүлэх, стандартуудыг танилцуулах, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх сургалт 2023 оны 4-р сарын 13-14-ний өдрүүдэд зохион байгууллаа. “Хөгжлийн шийдэл” ТББ-тай хамтран Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээлийн хүрээнд газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэлд олгогдох эргэлтийн болон хөрөнгө оруулалтын зээлийн сургалт хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Уг хэлэлцүүлэгт салбарын төлөөлөл 40 иргэн хамрагдлаа.

ТӨЛ БОЙЖИЛТ: 2023 оны 04 сарын 28-ний байдлаар: Мал төллөлт оны эхний төллөвөл зохих 2210600 толгой хээлтэгч мал төллөхөөс нийт 670161 толгой хээлтэгч төллөсөн үүнээс ингэ 67, гүү 6165, үнээ 29842, эм хонь 430697, эм ямаа 203390 мал төллөж байна.

Хээл хаясан хээлтэгч нийт 25105 толгой, гүү 682, үнээ 186, эм хонь 3168, эм ямаа 21069 толгой байна. Хорогдсон төл нийт 51604 толгой, ботго 3, унага 265, тугал 983, хурга 31757, ишиг 18596 толгой төл мал хорогдсон байна.

Төлөлтийн хувь 30.3 хувьтай, төл бойжилт 92 хувьтай байна. 2022 оны 04 сарын 28-ний өдрийн мэдээтэй харьцуулахад: Хээл хаясан хээлтэгчийн тоо 8.5 дахин нэмэгдсэн, Хорогдсон төлийн тоо 1.7 дахин нэмэгдсэн гарсан төлийн хорогдол хамгийн их сум Арбулаг, Бүрэнтогтох, Жаргалант, Рашаант, Цагаан-Уул, Шинэ-Идэр, хээлтэгч малын хээл хаялт хамгийн их байгаа нь Галт, Цагаан-Уул, Түнэл, Шинэ-Идэр гэх мэт сумд байна.

Малын хорогдол: Оны эхний 6254095 толгой том малаас нийт 53468 толгой хорогдсон байна. Үүнээс: адуу 1935, үхэр 4293, хонь 26023, ямаа 21217 мал хорогдож оны эхний нийт малаас 0.8 хувь нь хорогдсон байна.

2022 оны оны 5 сарын 18-ний өдрийн мэдээтэй харьцуулахад: Мал төллөлт 11.3 хувиар бага, төл малын хорогдол-6917 толгойгоор нэмэгдсэн байна. Том малын зүй бус хорогдол 42007 толгойгоор 4.6 дахин нэмэгдэж хорогдсон байна.

Малын хорогдол хамгийн их нэмэгдэж байгаа сум Ренчинлхүмбэ-6086 мал 2.7%, Жаргалант-6039 мал 2.1%, Бүрэнтогтох- 6854 мал 1.6%, Рашаант-5115 мал 1.8%, Цагаан-уул 6775 мал 1.2%, Галт-3755 мал 0.8%, Цагаан-нуур 702 мал 2.4%, Чандмань-өндөр 740 мал 1.0%- тай мал хорогдож оны эхний нийт малаас 0.8 хувь нь хорогдсон байна.

Сэлэнгэ аймагт зохион байгуулсан “Махны үхрийн аж ахуй эрхлэгчдийн зөвлөгөөн”-ий хүрээнд манай аймгаас 12 өрх, аж ахуйн нэгжүүдийн төлөөлөл “Гацуурт, Газар агро” компани болон Булган аймгийн Хутаг-Өндөр сум дахь “Занаду Разорбак” махны үхрийн аж ахуйн эрхэлдэг Жереми Тийссэний аж ахуй, Дархан-Уул аймгийн Малын удмын сангийн үндэсний төв”-ийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлан ажиллаа.

Хөвсгөл аймгийн Тариалан суманд болсон малчдын анхдугаар зөвлөгөөнд Мал үржлийн албаны мэргэжилтэн Н.Бэлэгдэмбэрэл, Б.Бэлэгдэмбэрэл нар оролцон малчдыг мэдээллээр ханган ажиллаа. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 90 морины хүчтэй хадлангийн иж бүрдэл тракторыг Рашаант, Жаргалант, Галт, Чандмань-Өндөр сумдад хүлээлгэн өгсөн.

Засагийн газрын “Хүнсний хувьсгал” 35-р тогтоолд тусгагдсаны дагуу явуулын лабораторийг үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд шаардлагатай зардлын тооцоо хийж, Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлэв.

Засгийн газрын 10 дугаар хуралдааны шийдвэр, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2023 оны 1 сарын 31-ны өдрийн А/19 тушаалаар батлагдсан “Дархлаажуулалтын төлөвлөгөө”, Засаг даргын 2023 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн А/156 дугаар захирамжийг хэрэгжилтийг ханган шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулан ажиллаж байна. Дархлаажуулалтын явц 270,906 мянган толгой мал хамрагдаж 43,1%-ийн гүйцэтгэлтэй хийгдэж байна.

Аймгийн хэмжээнд хийгдэж байгаа мал, амьтны сэг зэм устгал ариутгалын ажлыг эрчимжүүлэн ажиллаж байна. 2023 оны 05 дугаар сарын 04-ний байдлаар зүй бусын хорогдол 54,057 үүнээс халдваргүй өвчнөөр 3,820 халдварт өвчнөөр 188,гоц халдварт өвчнөөр 362 толгой мал тус тус хорогдсон байна.Сэг зэмийн устгалаар 19,641 толгой буюу 36 хувийг нь устгасан. Цаашид энэ тоо мэдээ өсөх хандлагатай байна.

Мал эмнэлгийн газрын албаны дарга Б.Мягмарсүрэн, улсын байцаагч Б.Батдорж нараар ахлуулсан 2 ажлын хэсэг Тариалан, Рашаант,Төмөрбулаг сумдад бог малын мялзан өвчний голомтод тандалт судалгаа, хяналтыг хийн ажиллаж байна. Аймгийн хэмжээнд нийт 4 голомтод 732 мал өвчилсөн үүнээс тусгаарлалтад 275, үхэж хорогдсон 159, шинж тэмдэг арилсан 404 толгой мал байна.

Төмөрбулаг сумын 1 голомт, Рашаант сумын 1 голомт хязгаарлалтын дэглэмд шилжсэн. Тариалан, Бүрэнтогтох сумдын тус тус1 голомт хорио цээрийн дэглэмтэй байна.

Байгаль орчин:

Үндэсний дасан зохицлын төлөвлөгөөний орон нутгийн хэлэлцүүлэг Хөвсгөл аймагт зохион байгуулагдлаа. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратегийн баримт бичиг, үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг салбар бүрийн тэргүүлэх эрдэмтэн судлаачдаас бүрдсэн үндэсний зөвлөхүүдийн баг Уур амьсгалын ногоон сангийн санхүүжилтээр Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Нэгдсэн Үндэсний Байгууллагын Байгаль орчны хөтөлбөр, Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төвийн хамтран хэрэгжүүлж буй “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төлөвлөлтийн процессыг боловсронгуй болгох үндэсний чадавхыг бэхжүүлэх” төслийн хүрээнд боловсруулсан төслийг Хөвсгөл аймагт хэлэлцүүлж санал авлаа.

БОАЖЯ, БШУЯ, ШХА-ын хамтран хэрэгжүүлж буй “Тогтвортой Хөгжлийн Боловсрол-II” төсөлд хамрагдсан Дэлгэрмөрөн, Рашаант, Авъяас, Хатгал, Цэцэрлэг сумын ЕБСургуулиудын төслийн үр дүнг танилцуулах өдөрлөг, туршлагаа хуваалцах арга хэмжээг хэрэгжүүллээ. Цаашид эдгээр 5 сургууль нь аймгийн хэмжээнд, улсын хэмжээний

сургуулиудад туршлагаа хуваалцах, тогтвортой хөгжлийн жишиг сургууль болж байгаагаараа онцлог юм.

“Могойн гол” ХК-ны 2022 оны БОМТөлөвлөгөөний биелэлтийг ажлын хэсгээр дүгнүүлж ажилласан. Дүгнэлтээр 90%-ийн үзүүлэлттэй буюу хангалттай гэж дүгнэгдсэн. “Могойн гол” ХК-ны 2022 оны БОМТ-ний биелэлт дүгнэсэн актыг www.eic.mn-д оруулж ажилласан. 2023 оны 04 дүгээр сарын 23-24-ны өдрүүдэд БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын удирдамжийн дагуу Цэцэрлэг сумын “Могойн гол” ХК, “Хургатай хайрхан” ХХК-ны үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж ажилласан

Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг Монголд зочлох жил болгон зарласантай холбогдуулан хөрсний бохирдлыг бууруулах, стандартын бус ариун цэврийн байгууламж болох нүхэн жорлонг буулгах талаар Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 02 дугаартай албан даалгаврын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Хангайн бүсийн уулзалт, зөвлөгөөнд ороцлоо. Зөвлөгөөнөөр бүсийн нутгийн хэмжээнд хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр урилга гаргах, сайдын албан даалгавар гаргуулж, аймгууд сум орон нутагтаа хэрэгжүүлэн ажиллахаар шийдвэрлэлээ.

“Сумдын байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн /БОХУБ/нарын мэдлэгийг дээшлүүлэх нь” сэдэвт сургалтын 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулж ажиллалаа. Сургалтын үеэр сумдын улсын байцаагч нарын тэмдгийг гардуулан өглөө.

“Хүсэхүйн цом” - 2023 төв, хангайн бүсийн аварга тогооч, зөөгч шалгаруулах, ур чадварын уралдаан Хөвсгөл аймаг Мөрөн хотод 50,100 эвент холлд 2023 оны 04 дүгээр сарын 27, 28, 29- ний өдрүүдэд зохион байгуулагдлаа. Үүнд Хөвсгөл, Архангай, Өвөрхангай, Булган, Эрдэнэт, Дархан, Төв, Сэлэнгэ аймгуудад үйл ажиллагаа явуулж буй хоолны газар /ресторан, баар, кафе, цайны газар, кофе шоп, цэцэрлэг, сургууль, аялал жуулчлалын байгууллагууд, үйлдвэр албан газрын дэргэдэх цайны газар/-ууд оролцсон. Тэмцээнд оролцохоор Орхон аймгаас 42 хүн ирсэн ба тэдгээр хүмүүсийг хариуцан ажилласан. Хөвсгөл аймгийн Цагаан-Уул, Цэцэрлэг, Эрдэнэбулган, Чандмань-Өндөр, Цагаан-Үүр сумдын 300 гаруй иргэдэд “Жорлонгоо өөрчилъе” сургалтыг амжилттай зохион байгуулж ажиллалаа.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 02 албан даалгавар, салбарын хяналтын газрын 01/06 удирдамжийн дагуу Мөрөн сумын нутаг дэвсгэрт байрлаж буй 13 шатахуун түгээх станцуудад Дэлгэрмөрөн-Шишхэд голын сав газрын захиргаа, Мөрөн сумын ЗДТГазрын хамтарсан хяналт шалгалтыг 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдрөөс 21-ний өдрүүдэд зохион байгууллаа.

Үүнд: Монсульт ШТС, Сод Монгол 67 ШТС, НИК-Мөрөн-1, 2 ШТС, МТ-94 ШТС, Дашваанжил газ ШТС, Шунхлай 1, 2, 3 ШТС зэрэг нийт 8 ШТС ариун цэврийн байгууламжийн нүхийг MNS 5924:2015 стандартад нийцүүлэн доторлосон байна. Мөрөн сумын авто зам дагуух эзэнгүй нүхэн жорлонг буулгаж, ариутгал хийж ажиллалаа.

Мөрөн сумын Байгаль орчин тогтвортой хөгжлийн бодлогын тасгаас БОАЖ-ын сайдын 02 албан даалгаврын хүрээнд сумын авто зам дагуух эзэнгүй нүхэн жорлонг бүрэн буулгаж ариутгал хийж булаах ажлыг зохион байгууллаа. Мөн шатахуун түгээх станцууд болон амралт, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуй нэгж

байгууллагуудад албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах хугацаатай мэдэгдэл хүргүүлж, усны тухай хууль тогтоомж, ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, журмыг танилцуулж стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болох нүхэн жорлонг буулгаж хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулах талаар зөвлөмж чиглэл өгч ажиллаж байна.

ХЯНАСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Х.ЦЭНД-АЮУШ

НЭГТГЭСЭН:

ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б.БАЯРМАА